

**БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ БОЛОН СОЁЛ, СПОРТ, ЗАЛУУЧУУДЫН  
ДЭД ХОРООДЫН БҮРЭЛДЭХҮҮНИЙ ТУХАЙ АСУУДЛЫГ ХЭЛЭЛЦСЭН ТАЛААРХ  
ХҮНИЙ ХӨГЖИЛ, НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ,  
ДҮГНЭЛТ**

2025 оны 07 дугаар  
сарын 09-ний өдөр

Улаанбаатар  
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн М.Ганхүлэг**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэг, 27.3.3 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн Боловсрол, шинжлэх ухааны болон Соёл, спорт, залуучуудын дэд хороодын бүрэлдэхүүний талаарх асуудлыг Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцээд дараах санал, дүгнэлтийг Та бүхэнд танилцуулж байна.

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын Намын бүлгийн дэд дарга А.Ариунзаяа дэд хороодын бүрэлдэхүүний талаар танилцуулга хийсэн болно.

Байнгын хорооны хуралдааны үед Улсын Их Хурлын гишүүн Д.Бум-Очир гишүүд 2 дэд хороонд орж ажиллах боломжтой эсэх талаар асуулт асууж, хариулт авлаа.

Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх Боловсрол, шинжлэх ухааны дэд хорооны бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүүн Ц.Баатархүү, Д.Бум-Очир, Ж.Галбадрах, А.Ганбаатар, С.Зул phar, Ц.Мөнхтуяа, Д.Рэгдэл, Г.Хосбаяр, Б.Хэрлэн нарыг, Соёл, спорт, залуучуудын дэд хорооны бүрэлдэхүүнд Ш.Бямбасүрэн, Д.Ганмаа, М.Ганхүлэг, М.Нарантуяа-Нара, О.Саранчулуун, М.Сарнай, Д.Энхтуяа, М.Энхцэцэг, С.Эрдэнэбат нарыг оруулах саналыг дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Боловсрол, шинжлэх ухааны болон Соёл, спорт, залуучуудын дэд хороодын бүрэлдэхүүний тухай асуудлыг хэлэлцсэн талаарх Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсандаа баярлалаа.

**УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН  
ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ**

*Л.Энхнаасан*

**Л.ЭНХНААСАН**

